



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/25

Баян-Өндөр сум

┌ Амин дэм худалдан авах, хуваарилах тухай ┐

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны "Аминдэм, эрдсийн бэлдмэл хэрэглэх заавар" батлах тухай А/490 дүгээр тушаал, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн "Аймгийн 2026 оны төсөв батлах тухай" 03/13 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2026 оны А/215 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жирэмсэн эхийн олон найрлагат бичил тэжээл, төмрийн бэлдмэлийн төсвийг нэгдүгээр, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд олгох аминдэмийн хуваарийг хоёрдугаар, зарцуулалтын тайлангийн маягтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аминдэмийн чанар, хадгалалт, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Эмийн бодлогын хэрэгжилт, чанар аюулгүй байдал, эмийн зохистой хэрэглээ, эм эмнэлгийн хэрэгслийн хангамж хариуцсан мэргэжилтэн (О.Анхбаяр), хавсралтын дагуу байгууллагад олгох, анхан шатны бүртгэлийг бүрдүүлж ажиллахыг нярав (Б.Алтанзагас) нарт үүрэг болгосугай.

3. Хуваарийн дагуу олгосон аминдэмийг жирэмсэн эмэгтэйчүүдэд олгож, бүртгэлжүүлэн үр дүнг тооцож тайлагнаж ажиллахыг Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Шаардлагатай зардал 9.982.800 (Есөн сая, есөн зуун наян хоёр мянга найман зуун) төгрөгийг "Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг аминдэмжүүлэх, эмчлэх зардал"-аас гаргахыг Салбарын санхүү, бүртгэл, мэдээлэл, нягтлан бодохын ажилтан (Н.Чулуун-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүн амын хоол тэжээл, зохистой хооллолт, амны хөндийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Т.Цэцэгсүрэн)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХЦЭЦЭГ

Эрүүл мэндийн газрын даргын 2026
оны 03 сарын 24 өдрийн 1/2 тусгаар
нэгдүгээр хавсралт



ЖИРЭМСЭН БОЛОН ХӨХҮҮЛ ЭХЧҮҮДИЙГ НЭМЭЛТ АМИНДЭМЭЭР ХАНГАХАД
ШААРДАГДАХ ТӨСӨВ

Д/Д	Аминдэмийн нэр, тун, тоо ширхэг	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ /төгрөг/	Нийт дүн /төгрөг/
1	GENTLE IRON 28мг	хайрцаг	161	34,800	5,602,800
2	Ferrum lek 100мг	хайрцаг	100	43,800	4,380,000
	Нийт	хайрцаг	261	-	9,982,800

Тооцоо хийсэн:

Т.Цэцэгсүрэн /ХАХТЗХАХАХМ/

Хянасан:

Н.Чулуун-Эрдэнэ /ССБМНБАжилтан/

Эрүүл мэндийн газрын даргын 2026
оны 03 сарын 24 өдрийн 1/2 тушаалын
хоёрдугаар хавиргалт



СУМ, ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮДЭД АМИНДЭМ СЭЛГЭХ ХУВААРЬ

№	СӨЭМТ	2026 оны эхний 2 сарын байдлаар		Ferrum lek 100мг		GENTLE IRON 28мг	
		Хяналтанд шинээр авсан жирэмсээн	Төрсөн эх	Төмрийн бэлдмэлийн тоо	хайрцаг	Амин дэмийн тоо	хайрцаг
1	Анхны оч ӨЭМТ	46	33	420	14	1980	22
2	Мэндцэцэн ӨЭМТ	61	68	450	15	1980	22
3	Нийцэл ӨЭМТ	48	26	360	12	1980	22
4	Үйлсбадрах ӨЭМТ	23	24	300	10	1350	15
5	Мөнхийнгэгээ ӨЭМТ	39	14	330	11	1800	20
6	Энхжинмандирваа ӨЭМТ	31	30	300	10	1620	18
7	Учралтбаяр ӨЭМТ	40	41	360	12	1620	18
8	Мөнхсүндэрэл ӨЭМТ	26	20	300	10	1350	15
9	Жаргалант СЭМТ	2	2	180	6	810	9
Нийт		316	258	3000	100	14490	161

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны
03 сарын 24 өдрийн 1/25 тушаалын
гуравдугаар хавсралт



Аминдэмийн зарцуулалтын маягт

Байгууллагын нэр.....

№	Аминдэмийн нэр	Хэмжих нэгж	Амин дэм хүлээн авсан тоо ширхэг	Амин дэмийн үлдэгдэл тоо ширхэг	Хүлээн авсан эхийн гарын үсэг	Хүлээлгэн өгсөн хүний гарын үсэг

Хөтөлсөн:.....

Хянасан:.....